

Зөвлөмж CM/Rec(2022)13

Европын Зөвлөлийн Сайд нарын хорооноос гишүүн орнуудад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд дижитал технологийн нөлөөллийн талаар

(Сайд нарын хороо 2022 оны 4-р сарын 6-ны өдөр баталсан Сайд нарын орлогч нарын 1431 хуралдаан дээр)

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд дижитал технологийн нөлөөллийн талаарх удирдамж

Хамрах хүрээ ба тодорхойлолт

Хүний эрхийн тухай Европын конвенцын 10 дугаар зүйлээр хамгаалагдсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь зөвхөн хувь хүний үндсэн эрх биш юм.

Энэ нь мөн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгээр ардчиллыг хамгаалах, бэхжүүлэх арга хэрэгсэл юм. Дижитал технологи нь энэ эрхийг дэмжиж, энэ зорилгод үйлчлэх боломжтой тэгэх ёстой.

Эдгээр удирдамж нь улс орны төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, ялангуяа Интернэт үйлчлэгч компани, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагууд, судлаач, боловсролын байгууллагууд болон бусад холбогдох оролцогч талууд дижитал эрин үед үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, дэмжих чиглэлээр бие даасан, хамтын хүчин чармайлт гаргахад нь туслах зорилготой юм. Удирдамжид дижитал технологи нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах бус, энэхүү эрх чөлөөнд эергээр нөлөөлөхөд чиглэсэн зарчмуудыг тодорхойлсон. Мөн хүний эрхэд нийцсэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд дижитал технологийг өргөнөөр ашиглахтай холбоотой сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулах, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх талаар зөвлөмж өгсөн болно.

Сайд нарын хорооноос гишүүн орнуудад өгсөн CM/Rec(2018)2 зөвлөмжид Интернэтийн зуучлагчдын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон болно. "Интернэт зуучлагч" янз бүрийн үйлчилгээг нэгэн зэрэг үзүүлдэг гэдгийг харгалзаж, энэхүү удирдамжид холбогдох тодорхой чиг үүргийн талаар дурдсан болно.

Удирдамжид дурдсан "Хувийн нууц" гэх нэр томъёог нэмэлт өөрчлөлт оруулах Протоколоор (CETS No 223) шинэчилсэн Хувийн мэдээллийг автоматаар боловсруулахтай холбоотой хувь хүнийг хамгаалах конвенцид (ETS No. 108) нийцүүлэн ойлгоно (цаашид "Конвенци 108" гэх), түүнчлэн Европын Хүний эрхийн шүүхийн практик эрх зүйн актад хувийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байгаа эсэх, тухайн мэдээллийг дижитал хэрэгслээр эсвэл өөр аргаар бий болгосон эсэхээс үл хамааран "хувийн нууц"-ад хамаатуулан ашигласан болно.

Удирдамжид хувийн мэдээлэл боловсруулах, тэр дундаа мэдээлэл солилцох, хил дамнансан өгөгдөл дамжуулах тухай дурдах бүрд 108-р конвенц, ялангуяа нууц

мэдээллийг боловсруулахад тавигдах сайжруулсан шаардлага болон бусад хамгаалалт, баталгааны утга санааг агуулж дурдсан болно.

Удирдамжийг дараах зургаан бүлэгт хуваасан болно: хүний эрхийг дээдэлсэн хууль журмын үндэс суурь; дижитал дэд бүтцийн дизайн; ил тод байдал; хариуцлага, нөхөн төлбөр; боловсрол, эрх мэдэл; нотолгоонд суурилсан хууль журамд зориулсан бие даасан судалгаа.

1. Хүний эрхийг дээдэлсэн хууль журам тогтоох үндэс

1.1. Тодорхой бөгөөд хоёрдмол утгагүй зорилтууд. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж болзошгүй дижитал технологийн аливаа өөрийн зохицуулалт, хамтын болон хөндлөнгийн зохицуулалт нь хууль бус контент түгээхэд авах хариу арга хэмжээ болон Конвенцийн 10 дугаар зүйлд заасан хууль ёсны бөгөөд хамгаалагдсан эрхийн хариу арга хэмжээг тодорхой ялгаж, салгах ёстой. Төрийн зохицуулалт нь зөвхөн хууль бус контент түгээхийг хязгаарлах ёстой бөгөөд ийм хязгаарлалтыг Конвенцийн 10.2-т нийцүүлэн боловсруулах ёстой. Хууль ёсны боловч Конвенцид заасан хүний бусад эрхийг зөрчиж болзошгүй агуулгын хувьд эдгээр удирдамжийн 1.5-д заасны дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах бус хамгаалалтыг эрэмбэлэх өөр арга хэмжээг эрэлхийлэх хэрэгтэй. Хүний эрхийг хамгаалах үүрэгтэй уялдуулан улсууд өөрийн болон хамтран зохицуулах арга барилыг оролцуулан бүх зохицуулалтын хүрээ конвенцид нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах ёстой.

1.2. Хууль ёсны байдал, шаардлага хэрэгцээ, урьдчилан таамаглах боломжтой байдал. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зорилго бүхий төрийн аливаа бодлого, үйл ажиллагааг заавал хуулиар тогтоосон байх, Конвенцийн 10.2-т заасан хууль ёсны зорилгын аль нэгийг хэрэгжүүлэх зорилготой байх, хор хохиролтой уялдсан зохистой арга хэрэгслийг ашиглах, эрх зүйн хувьд тодорхой, зайлшгүй, урьдчилан таамаглах боломжтой байх шаардлагыг хангасан байх ёстой.

1.3. Нарийвчлал. Төрөөс зөвхөн хуулиар тодорхойлсон үг хэллэг, агуулгын төрлийг зохицуулна. Тодорхой бус бөгөөд субъектив тайлбарт үндэслэсэн нэр томьёо, тодорхойлолтыг зүйн практикт ашиглахаас зайлсхийх хэрэгтэй. Учир нь ерөнхий агуулгатай, субъектив тайлбарлах боломжтой томьёолол нь хангалттай тодорхой, урьдчилан таамаглах боломжтой байх шалгуурыг хангахгүй учир үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд зүй бус, үндэслэлгүй саад учруулж болзошгүй юм.

1.4. Зохистой байдал. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах аливаа зохицуулалт, дагаж мөрдөх шаардлага, захиргааны үйл явц нь янз бүрийн Интернэт үйлчилгээний компаниудын эрсдэлийн түвшин, хэмжээ, хүчин чадлыг харгалзсан зохистой байх ёстой. Төрөөс зөвхөн маш том Интернэт үйлчилгээний компани болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа явуулдаг компаниудад томоохон үүрэг хариуцлага хүлээлгэх ёстой. Төрөл бүрийн Интернэт зуучлагч компанийн хэмжээ, хүчин чадал, эрсдэлийн

түвшнийг үнэлэх шалгуурыг тодорхой томъёолж, тогтмол хянаж, ил тод мэдээлэх байх ёстой.

1.5. Шаталсан хариу арга хэмжээ. Төрөөс аливаа зохицуулалтын үйл ажиллагаа санаачлахдаа Интернэт үйлчилгээний компаниуд контентыг устгахаас гадна контент зохицуулах янз бүрийн арга техникийг ашиглаж болно гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Эдгээр арга техникт, жишээлбэл, контентын ач холбогдлыг өндөрсгөх, тэргүүлэх ач холбогдолгүй болгох, байршлыг дээшлүүлж, доошлуулах, төлбөр хураамжтай болгох, (боломжтой бол) болон албан ёсны болон хараат бус эрх бүхий эх сурвалжаас авсан сэрэмжлүүлэг, зэрэг нэмэлт мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх зэрэг арга хэрэгсэл орж болно. Эдгээр арга техникийг ашиглахдаа Интернэт үйлчилгээний компаниуд ил тод байдлыг хангах, зохицуулалтыг урьдчилан мэдэх буюу таамаглах боломжтой байлгах, хяналтад байлгахад гадна үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах шаардлагыг хангах ёстой.

1.5. Эрэмбэлсэн хариулт. Интернэт үйлчилгээний компаниуд янз бүрийн контентыг зохицуулах төрөл бүрийн арга техникийг ашиглаж болно гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Тухайлбал контентын илэрцийн эрэмбийг бууруулах, төлбөр тогтоох эсвэл үнэ төлбөргүй болгох (хамаарах нөхцөлд) болон албан ёсны болон хараат бус эрх бүхий эх сурвалжийн сэрэмжлүүлэг, тайлбар зэргийг хэрэглэгчдэд хүргэх зэргийг дурдаж болно. Эдгээр аргыг ашиглахдаа Интернэт үйлчилгээний компаниуд ил тод байх, урьдчилан тооцоолох боломжтой байх, хянах боломжтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах зарчмыг хангах ёстой.

1.6. Үйл явцад анхаарлаа төвлөрүүл. Зохицуулалт, хамтын зохицуулалт нь контент дээр бус Интернэт компаниуд агуулгыг хэрхэн эрэмбэлж, зохицуулж байгаа үйл явцад анхаарлыг хандуулах ёстой.

1.7. Хэрэглэгчийг чадавхжуул. Зохицуулах, хамтран зохицуулах болон өөрийн зохицуулалтын санаачилга нь хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад хэт их шаардлага тавихгүйгээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд дижитал технологийн нөлөөллийн талаарх ойлголт, сонголт, хяналтыг өргөжүүлэхэд чиглэх ёстой.

1.8. Хамгаалалт. Дижитал технологийн дэвшлийн үр дүнд мэдээллийн хурд, цар хүрээ, хэмжээ эрс нэмэгдэж дарамт шахалт, сүрдүүлэг зэрэгт өртсөн хүмүүс ихээхэн хохирол амсдаг. Ийм үйл ажиллагааны хохирогчдод гэмт хэрэг үйлдэгчдийг мэдээлэх, хохирлыг барагдуулах боломжийг бол болгох ёстой.

1.9. Хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ. Дижитал технологи, тэдгээрийн хэрэглээ байнга өөрчлөгдөж байгааг харгалзан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж буй тогтмол хянаж байх нь зүйтэй. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нөлөөлж болзошгүй хөндлөнгийн оролцоог судлахдаа юун түрүүнд хүний эрхийн нөлөөллийн үнэлгээг хийж, нийтэд ил болгох ёстой. Тийнхүү гүйцэтгэсэн үнэлгээ судалгааны үр дүнд хөндлөнгийн оролцоо нь хүний эрхэд эрсдэл учруулж байна гэх дүгнэлт гарвал ийм эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

1.10. Нууцлал. Хувь хүн мэдээллээ нууцлах, өөрийн талаарх мэдээллийг хэрхэхээ өөрөө шийдэх эрхэд хувийн хэвшил болон төрөөс технологийн нарийн арга, хэрэгслийн тусламжтайгаар халдах боломжтой байдаг. Төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын аливаа үйл ажиллагаа нь Конвенцийн 8 дугаар зүйл болон 108-р конвенц зэрэг хувийн нууц, мэдээлэл хамгаалах хууль эрх зүйн зохицуулалттай нийцэх ёстой. Мөн төр, хувийн хэвшлийн оролцогчид Сайд нарын хорооноос гишүүн орнуудад алгоритмын системийн хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн тухай 1 тоот, алгоритмын үйл явцыг гуйвуулах үйл ажиллагааны тухай Сайд нарын хорооны тунхаглалын (2019 оны 2-р сарын 13) CM/Rec(2020) зөвлөмжид тусгасан нууцлалын заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

1.11. Олон талт хамтын ажиллагаа. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нөлөөлөх дижитал технологийн зохицуулалт, бодлого, удирдамжийг Засгийн газар, парламент, олон улсын байгууллага, Интернет үйлчилгээний компани, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачид болон бусад хүмүүсийн бүрэн оролцоотойгоор боловсруулах шаардлагатай. Хамтын ажиллагааны энэхүү үйл явц нь тодорхой ойлгомжтой байж, харилцан тохиролцсон цар хүрээ, чадамжид суурилсан байх ёстой, мөн хангалттай санхүүжилттэй, холбогдох бүх оролцогч талуудыг шаардлагатай мэдээллээр хангах, санал хүсэлтийг шийдвэрлэх хялбаршуулсан журам, үр дүнг хэрэгжүүлэхэд хэн хариуцлага хүлээхийг тодорхой байх ёстой. Интернетийн засаглалын зарчмын тухай Сайд нарын хорооны тунхаглалд (2011 оны 9-р сарын 21) заасны дагуу олон улсын түвшний бодлого, засаглалын зохицуулалтыг хөгжүүлэх үйл явцад бүх улс орны бүх оролцогч талуудын бүрэн, тэгш оролцоог хангах ёстой.

2. Дижитал дэд бүтцийн загвар

2.1. Ардчилсан нийгэм дэх харилцаа холбооны дижитал дэд бүтэц нь хүний эрх, нээлттэй байдал, харилцан дэмжлэг, ил тод байдал, шударга өрсөлдөөнийг дэмжих зорилготой байх ёстой.

2.2. Төр, Интернет үйлчилгээний компаниуд үр дүнтэй өрсөлдөөнийг дэмжихийн тулд шударга, үндэслэлтэй, ялгаварлан гадуурхахгүй нөхцөлөөр тоон дэд бүтцийг ашиглах боломжийг олгох ёстой.

2.3. Интернет үйлчилгээний компаниуд гуравдагч этгээдэд үл ялгаварлан гадуурхах, шударгаар үйлчлэх, өгөгдөл зөөвөрлөх, харилцан зохицох нөхцөлөөр хэрэглэгчдэд үйлчлэх боломжийг олгох ёстой. Хандалт болон ашиглалтын нөхцөл нь хэрэглэгчийг гарцаагүй байдалд оруулах ёсгүй.

2.4. Төрийн зохицуулалт нь хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны зах зээлд өрсөлдөөнийг хөгжүүлэн дэмжих ёстой. Хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны зах зээл дэх төвлөрлийг сааруулахын тулд өрсөлдөөний тухай хуулийг хэрэгжүүлэх, шаардлагатай бол өөрчлөх нь зүйтэй. Үүний зэрэгцээ олон нийтийн анхаарлыг ямар нөхцөлд арилжааны зорилгоор төвлөрүүлж болох, үүнийг хэрхэн яаж хэрэгжүүлэх боломжтой байх зэргийг харгалзан хэвлэл мэдээллийн төвлөрлийг сааруулах бодлогыг шинэчлэх ёстой. Ингэснээр улам бүр төвлөрч буй олон нийтийн санаа бодлыг төвлүүлэх эрх мэдлийн эсрэг олон ургалч байдлыг дэмжих нь чухал.

2.5. Төрөөс өрсөлдөөн, хэвлэл мэдээллийн төвлөрөлтэй холбоотой эрх мэдэл, бодлого зохицуулалтыг ашиглан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон бусад хүний эрхийг хязгаарлах байдлаар Интернэт үйлчилгээний компаниудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох ёсгүй.

2.6. Төрөөс олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийж, төрийн болон улс төрийн хөндлөнгийн нөлөөллөөс ангид байлгах, үүрэг, хариуцлагыг нь тодорхой болгох, хувийн хэвшлийн мэдээллийн хэрэгсэлд зах зээлийн орон зайг нь үлдээх, бүх хэрэглэгч, тэр дундаа залуу үеийнхэнд үйлчлэх зохицуулалт, засаглалын тогтолцоог бий болгож хадгалах ёстой. Мөн төрөөс редакцын хараат бус байдалд нь саад учруулахгүйгээр ижил үүрэг, зорилгыг биелүүлж чадах хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжих ёстой. Энэ нь ялангуяа орон өндөр нэр хүнд, итгэл үнэмшилтэй, ардчилсан засаглалд чухал үүрэг гүйцэтгэдэг орон нутгийн болон бүс нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хамаатай.

2.7. Төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагуудын дижитал өөрчлөлтийг идэвхжүүлж, тэдний чадавхыг сайжруулах цахим технологид хөрөнгө оруулалт хийх, жишээлбэл, үнэгүй, нээлттэй программ хангамж, дэд бүтцийн хөгжилд олон төсвийн дэмжлэг үзүүлэх замаар дэмжих ёстой.

3. Ил тод байдал

3.1. Интернэт үйлчилгээний компаниуд өөрийн бодлого, түүний хэрэгжилт нь олон нийт, эмзэг бүлгийн хувь хүн, бүлгүүдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж буйг судлах, ил тод болгоход шаардлагатай бүх мэдээллийг бэлтгэн нийтлэхийг төрийн зохицуулалтаар баталгаажуулах ёстой.

3.2. Интернэт үйлчилгээний компаниудын ил тод байдлыг хангахад шаардлагатай мэдээллийн бүрэн бүтэн байдал, үнэн зөвийг шударгаар хянаж баталгаажуулах бие даасан механизмыг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд бий болгох бөгөөд гишүүн орнууд энэхүү үйл явцыг дэмжих ёстой.

3.3. Интернэт үйлчилгээний компаниуд бодлогоо янз бүрийн түвшинд ил тод байлгахын тулд шаардлагатай бүхий л мэдээллийг компьютераар унших боломжтой хэлбэрээр нийтлэх, мөн хэрэглэгчдийг чадавхжуулах, гуравдагч этгээдийн аудит, хяналтыг идэвхжүүлэх, асуудалтай контентыг эсэргүүцэх бие даасан хүчин чармайлтыг мэдээлэх зэргээр ажиллах ёстой. Ил тод байдлын шаардлага, шалгуур нь янз бүрийн Интернэт компанийн хүчин чадал, үйл ажиллагаа, эрсдэлийн түвшнийг харгалзсан, зохистой байх ёстой.

3.4. Интернэт үйлчилгээний компаниуд контент устгах, зөвлөмж өгөх, түгээх, сурталчлах, "дэмжих", орлого бүрдүүлэхтэй холбоотой бодлого, ялангуяа тэдгээр бодлого, үйл ажиллагаа нь үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэрхэн нөлөөлөхтэй холбоотой бүхий л үйлчилгээний нөхцөл, хэм хэмжээний талаарх ил тод байдлыг хангах ёстой.

3.5. Интернэт зуучлагчид өөрсдийн үндсэн бодлого, үйлчилгээний нөхцөлийг бий болгох, өөрчлөн шинэчлэх тохиолдолд холбогдох төрийн болон хувийн оролцогч талуудыг нээлттэй, ил тод, утга учиртай зөвлөлдөх ёстой. Түүнчлэн тэдгээр бодлого, үйлчилгээний нөхцөл нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хүний бусад эрхэд хэрхэн нөлөөлж байгааг судлах ёстой. Интернэт зуучлагчид эдгээр

зөвлөгөөний явц, агуулга, хүлээн авсан санал хүсэлт, тэдгээрийн харгалзсан эсэх, хэрхэн тусгасан зэргийг ил тод болгож, тайлбарлах ёстой.

3.6. Интернэт үйлчилгээний компаниудын бодлого үйл ажиллагаа нь ялгаварлан гадуурхалтад хүргэж болзошгүй гэсэн хууль ёсны бөгөөд үндэслэлтэй болгоомжлол байх нөхцөлд хараат бус гуравдагч этгээдээр үнэлгээ хийлгэх боломж олгох, тэр дундаа алгоритмын хазайлтын эх үүсвэрийг тодорхойлох, автоматжуулсан системийн ажиллагааг шалгах ёстой.

4. Хариуцлага, нөхөн төлбөр

4.1. Зохицуулалтын үр дүнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө хязгаарлуулсан аливаа этгээд эдгээр энгийн, хүртээмжтэй, боломжийн аргаар шүүхэд хандах боломжтой байх ёстой.

4.2. Интернэтийн компаниудын үйлчилгээний нөхцөл, контентыг зохицуулах бодлогын үр дүнд хэвлэн нийтлэгчийн редакцын хараат бус байдал заналхийлэлд өртсөн тохиолдолд цаг алдалгүй үр дүнтэй арга хэмжээ авах, тэр дундаа хохирлыг барагдуулах механизм ашиглах боломжийг гишүүн орнууд баталгаажуулах ёстой.

4.3. Дижитал технологи үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж буйг үр дүнтэй хянахын тулд зохицуулах үүрэг бүхий холбогдох бүх байгууллагыг бэхжүүлж, зохих нөөц, мэргэшлийн боловсон хүчнээр хангах ёстой. Гишүүн орнууд мөн эдгээр хяналтын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллээр Интернэт үйлчилгээний компаниудыг цаг тухайд нь хангах ёстой.

4.4. Европын Хүний эрхийн шүүхээс тайлбарласнаар, Конвенцийн 15 дугаар зүйлд заасны дагуу шаардлагатай тохиолдолд, ялангуяа онц байдлын үед олон нийтийн ашиг сонирхолд үйлчлэх контентыг түгээх зорилгоор Интернэт компаниудад зохих үүрэг хариуцлага хүлээлгэж болно. Интернэт компаниуд олон нийтийн ашиг сонирхол үйлчлэх контентыг илүү өндөр түвшинд хамгаалах ёстой бөгөөд энэхүү хамгаалалтын журам нь тодорхой, ялгаварлан гадуурхах эрсдэлгүй, ил тод байх ёстой.

4.5. Интернэт үйлчилгээний компаниуд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт хийхдээ уг зохицуулалтын үр дагаврыг шууд болон шууд бусаар хүртэж буй хэрэглэгчдэд тухайн зохицуулалтын талаар тодорхой мэдээлэл өгөх ёстой. Тухайлбал, эрх нь хохирсон хэрэглэгчид хэрхэн гомдол мэдүүлэх, гомдлыг хэн хэзээ хэрхэн шийдвэрлэх талаар мэдээллээр хангах үүрэгтэй байна. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхийн тулд Европын Зөвлөлийн агуулга зохицуулалтын өөрийн болон болон хамтран зохицуулах механизмыг бий болгох шилдэг туршлагын талаарх зөвлөмжийг харгалзана.

4.6. Интернэтийн зуучлагчид хэрэглэгчдийн санал хүсэлтэд үндэслэн үндсэн бодлогоо хэрхэн сайжруулж, хэрэгжүүлэх үйл явц, журмыг бий болгож, улмаар ирээдүйд гарах гомдол, хохирлоос урьдчилан сэргийлэх ёстой.

4.7. Энэхүү удирдамжийн 1.1-д заасан зарчмуудын хүрээнд, олон нийтэд ихээхэн хохирол учруулахуйц контент тархах нөхцөлд Интернэт үйлчилгээний компани тухайн контентыг устгах ёстой. Гагцхүү ямар контентыг үл зөвшөөрөх, ямар үед устгах тухай дүрэм, зохицуулалт нь ил тод байна. Интернэт компани мөн эрх бүхий байгууллагаас гаргасан залруулга, сэрэмжлүүлгийг аль болох хурдан түгээх

бөгөөд залруулгын уг арга нь учирч болзошгүй хохиролтой дүйцэхүйц байх ёстой.

5. Боловсрол ба эрх мэдэл

5.1. Гишүүн орнууд хувийн нууц, мэдээллийн ашиглалтыг өөрөө шийдэх эрхийг хамгаалах ёстой. Үүний тулд хэрэглэгчдэд өөрсдийн үүсгэсэн өгөгдөл, тэдгээрийн үр дагаврыг хянах боломж олгоно. Гишүүн орнууд Интернэт компаниас алгоритмын системийн үйл ажиллагаа, тухайлбал өгөгдөл боловсруулах үйл ажиллагааны зорилго, боломжит үр дүнгийн талаарх мэдээлэл, уялдаа холбоог ил тод байлгах шаардлага тавих ёстой. Хэрэглэгчид өөрсдийн мэдээллийг арилжааны зорилгоор хэрхэн ашиглах гэж буйг мэдэж, хянах боломжтой байх ёстой. Түүнчлэн хэрэглэгчид өөрсдийн тухай мэдээллийг цахим орчинд хадгалах, арилжааны зорилгоор ашиглах нөхцөлийг хялбар аргаар хурдан өөрчлөх боломжтой байх ёстой.

5.2. Дижитал технологи үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж буй, төрөл бүрийн мэдээллийг хэн, хэрхэн бүтээж, түгээж, боловсруулдаг, мөн хувь хүмүүс эрх ашгаа хэрхэн хамгаалах арга замыг ойлгоход шаардлагатай тоон бичиг үсгийн боловсролыг бүх хүнд олгох ёстой. Түүнчлэн гишүүн орнууд төрийн болон олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, их дээд сургуулиуд, хэрэглэгчдийн бүлэг, иргэний нийгмийн оролцогчид, Интернэтийн зуучлагчид болон бусад талуудын боловсролыг дэмжих идэвх санаачилгыг дэмжих ёстой. Нэн ялангуяа эмзэг бүлгийнхэн, чанартай мэдээлэл хүлээн авах боломж хязгаарлагдмал хүмүүсийг чадавхжуулахад онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.

5.3. Дижитал бичиг үсгийн хөтөлбөр нь дижитал төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн төрөл, өгөгдөл, тэдгээрийг үүсгэх үйл явц, хэрэглэгчийн зан төлөв, алгоритм хэрхэн ажилладаг, хувийн болон төрийн янз бүрийн байгууллага цахим орчин дахь мэдээллийг нөлөөллийн зорилгоор хэрхэн ашигладаг тухай зэрэг мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд чиглэнэ. Түүнчлэн тоон бичиг үсгийн хөтөлбөрт хэрэглэгчид өөрсдийн мэдээллийг хэрхэн хамгаалах, хянах тухай агуулгыг багтаах нь чухал юм.

5.4. Дижитал бичиг үсгийн хөтөлбөр нягт нямбай, бие даасан судалгааны мэдээлэлд суурилсан байх ёстой; Ийм хөтөлбөрийн үр дүнд хэрэглэгчид өөрсдийнх нь эрх хэрхэн хохирч болох, эрхээ хэрхэн хамгаалах, хохирлоо хэрхэн барагдуулах тухай мэдлэг олж авах боломжтой байна.

5.5. Гишүүн орнууд дижитал технологийн тусламжтайгаар мэдээллийн технологийн хэрэглээ болон хууль бус цахим үйл ажиллагааг хэрхэн ялгах талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж, нотолгоонд суурилсан удирдамжаар хангах мэргэжилтнүүд болон шинжлэх ухааны нийгэмлэгүүдийг чадавхжуулах ёстой. Ийм хэлэлцүүлгийн үр дүнг төрийн бодлого, дижитал бичиг үсгийн хөтөлбөрт тусгах нь зүйтэй.

6. Судалгаанд үндэслэсэн зохицуулалт

6.1. Дижитал технологи хүний эрх, ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэрхэн нөлөөлөх боломжтойг нийгэм, улс төр, хууль эрх зүй, соёлын өөр өөр

нөхцөл байдалд судалж, нотлох баримтыг бий болгох, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, бодлого боловсруулах өрнүүлэх зорилго бүхий бие даасан судалгаанд хангалттай санхүүжилт олгох нь зүйтэй.

6.2. Конвенцын 8 дугаар зүйлд заасан эрхийг хамгаалахын зэрэгцээ Интернэт үйлчилгээний компанийн эзэмшиж буй өгөгдлийг судлаачид найдвартай, хууль ёсны аргаар хүлээн авч ашиглах боломжтой байх ёстой. Судалгааны зорилгоор хувийн мэдээллийг ашиглах шаардлагатай тохиолдолд тухайн хэрэглээ нь зохистой, зайлшгүй байх зарчмуудыг чанд дагаж мөрдөх шаардлагатай. Судалгаа нь хэрэглэгчийн хувийн нууцыг хамгаалах эрх, холбогдох мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийг үргэлж хүндэтгэж, хувийн мэдээллийг боловсруулах эрх зүйн зохих үндэслэлтэй байх ёстой бөгөөд ёс зүйтэй, хариуцлагатай байх ёстой. Гишүүн орнууд Интернэт зуучлагчдын эзэмшдэг ямар мэдээллийг бие даасан судлаачидтай хуваалцаж болохыг тодорхой тогтоох ёстой. Үүнийг хууль тогтоомжид заагаагүй тохиолдолд зохицуулах байгууллага нь хэрэглэгчдийн хувийн нууцыг хамгаалах, нийтийн ашиг сонирхолд нийцсэн бие даасан судалгаа явуулах эрхийг хамгаалсан байдлаар тайлбарлах ёстой.

6.3. Хүний эрх, эрх чөлөөнд дижитал технологи ямар үр дагаврыг дагуулж буйг судлах, шийдвэрлэх зорилгоор Интернэт үйлчилгээний компаниудын хууль ёсны дагуу цуглуулсан өгөгдлийг холбогдох хууль, журмын дагуу ашиглаж, боловсруулж болно. 108 дугаар конвенцид заасны дагуу шинжлэх ухаан, түүхийн судалгаа, статистик, архивын зорилгоор хэрэгжүүлсэн ийм судалгаа нь хүний үндсэн эрхийг зөрчих эрсдэлгүй байх тохиолдолд нийтийн ашиг сонирхлын шаардлагыг хангасан гэж ойлгоно.

6.4. Хүний эрх, ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх зорилгоор дижитал технологийг ашиглах нь нийгэм, хувь хүнд ямар үр дагавартай байх талаар судлахад шаардлагатай аюулгүй орчныг үндэсний эрх бүхий байгууллагууд, судлаачид болон Интернэт зуучлагчид хамтран бүрдүүлэх ёстой. Үндэсний хууль тогтоомжид ийм аюулгүй орчныг бий болгох, хянах үйл явц, нөхцөлийг нэмж тодорхойлж болно. Эдгээр орчныг бий болгохын өмнө хувийн болон хувийн бус мэдээллийг хэрхэн ялгах талаар өргөн хүрээний хэлэлцүүлэг хийх ёстой. Үүнд ямар хувийн мэдээллийг ямар платформиос, ямар аргаар ашиглах боломжтой байх; Интернэт зуучлагчдын хуваалцсан мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тулд ямар систем, технологийг нэвтрүүлэх шаардлагатай; хяналтын болон шүүх эрх мэдлийн байгууллагуудыг оролцуулан бүх боловсруулалтын үйл ажиллагаанд бие даасан үр дүнтэй хяналтыг хэрхэн хангах талаар Эдгээр орчинд ажиллаж буй судлаачид мэдээллийн хамгаалалт болон бусад холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

6.5. Интернэт зуучлагчид дижитал технологи хүний эрх, ялангуяа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж буйн талаар бие даасан, төлөөлөх чадвартай судалгаа зохион байгуулахад шаардлагатай үнэн зөв мэдээллийг бэлтгэж өгөх ёстой. Хувийн мэдээллийг холбогдох хуулийн хүрээнд, зохистой байх, зайлшгүй шаардлагатай байх, арилжааны болон улс төрийн нөлөөллөөс ангид байх зэрэг Конвенцийн 108-д заасан зарчимд үндэслэн ашиглуулна. Судалгааны зорилгоор бусдад хуваалцсан хувийн мэдээллийг нэргүйгээр

ашиглах, шаардлагатай бол хамгийн сүүлийн үеийн техникийг ашиглан хуурамч өөр нэрээр нууцлах ёстой.

6.6. Судлаачид мэргэшил, тухайн төслийн ач холбогдол зэргийн үндсэн дээр бие даасан шинжлэх ухааны байгууллагаас баталгаажсан, аль нэг их дээд сургуульд харьяалагддаг, холбогдох ёс зүйн шалгуурын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлд л Интернэт компаниудын эзэмшиж буй хувь хүний мэдээллийг ашиглах боломжтой байна. Төрийн байгууллагууд бие даасан судалгааны байгууллагуудыг тогтмол магадлан итгэмжлэх механизмыг бий болгож, тэдгээрт ажилладаг судлаачдад Интернэт зуучлагчдын эзэмшиж буй мэдээлэлд нэвтрэх эрхийг ижил нөхцөлөөр олгох нь зүйтэй. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд их, дээд сургуулийн харьяа судлаачид болон судалгааны байгууллага, мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх ёстой.

6.7. Интернэт үйлчилгээний компаниудын хуваалцсан мэдээллийг хэрэглэгчийн нууцлал болон хуулийн бусад заалтыг зөрчиж боловсруулсан тохиолдолд судлаачид болон тэдгээрийн ажил олгогч байгууллага хамтран хариуцлага хүлээх ёстой. Ийм хамтын хариуцлага нь үндэсний хууль тогтоомжтой нийцэхгүй байх тохиолдолд судлаачдын ийм хариуцлагыг тогтолцоог бий болгох замаар судлаачдын ёс зүй, судалгааны байгууллагын хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

6.8. Судлаачдын хараат бус байдлыг хамгаалахын тулд Интернэт үйлчилгээний компаниуд судлаачидтай мэдээлэл солилцох гэрээ байгуулж, энэхүү гэрээнд Интернэт үйлчилгээний компани мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэвлэн нийтлэх үйл явцад хөндлөнгөөс оролцохгүй гэдгийг тодотгох ёстой. Хувийн мэдээлэлтэй холбоотой мэдээлэл солилцох гэрээ нь 108 дугаар конвенц болон холбогдох олон улсын мэдээлэл хамгаалах стандартад нийцсэн байх ёстой. Бие даасан шинжлэх ухааны байгууллагууд, мэдээлэл хамгаалах байгууллагууд эдгээр гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, аливаа маргааныг шийдвэрлэх ёстой.

6.9. Интернэт үйлчилгээний компаниуд өөрсдийн өгөгдлийг судалгааны зорилгоор ашиглуулахад хувийн нууц, мэдээлэл хамгаалах эрхийг зөрчих, хууль тогтоомжийг өөр хэлбэрээр зөрчихөөс татгалзах эрхтэй байх ёстой. Тэд холбогдох хуулийн дагуу судлаачидтай мэдээллээ хуваалцаж, хэрэглэгчийн хувийн нууцын зохих хамгаалалт, тэр дундаа мэдээллийн тусгай ангилалд зориулсан нэмэлт хамгаалалтыг хангасан тохиолдолд ийм мэдээллийг шууд болон дангаараа хуваалцахаас үүсэх хариуцлагаас хамгаалагдсан байх ёстой.

6.10. Интернэт үйлчилгээний компаниудын үйлчилгээний нөхцөл нь дижитал технологийн үр нөлөөтэй холбоотой судалгааны үйл ажиллагааг ялгаварлах ёсгүй. Мөн ёс зүйн хэм хэмжээг сахиулах байгууллагаас судалгааны эрх авсан судлаачид судалгаа хийх явцад Интернэт зуучлагчдын үйлчилгээний нөхцөлийг зөрчсөн гэсэн үндэслэлээр хариуцлага хүлээх ёсгүй.